

# Манмин Мэдээ

№ 52 2014 оны 11 сарын 2

## “Амийн үг сургаал ба эрх мэдэлт хүчний нөлөөгөөр олон хүмүүсийг үнэний зам руу”

Юуны өмнө Бурханы хаанчлал, ба Түүний зөвт байдлыг эрхэмлэдэг эрэгтэйчүүдийн бүлгийн удирдагчид



2014 оны 8 сарын 24нд Дүүргийн ахлагчдын зөвлөл, Бүлгийн удирдагчдын зөвлөл, Эсийн бүлгийн удирдагчдын зөвлөлийн уулзалт дээр (Зүүн дээд талд, Дүүргийн ахлагч нар; баруун дээд талд, бүлгийн удирдагч нар; доод талд нь эсийн бүлгийн удирдагч нар)

Манмин Төв Сүмийн зохион байгуулалт ба үйлчлэлийн хэсэг нь (нас, насаар нь), орон нутгийг хэсэг (оршин суугаа газраар нь) гэсэн үндсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Орон нутгийн хэсэг нь гурван том тойргоос бүрдэх бөгөөд тус бүр их тойрог, тойрог, дүүрэг, бүлэг, эсийн бүлэг гэсэн хэсэгт хуваагддаг.

2014 онд зохион байгуулалтын хувьд шинэчлэгдсэн эрэгтэйчүүдийн бүлгийн удирдагч нар Эзний өдөр бүр сургааль үгсээр зэвсэглэж, (1 Коринт 4:20) д дурьдсанчлан Бурханы хаанчлал нь үг ярианд бус харин хүч дотор байна гэдэг үгийн дагуу арвин их үр жимс боловсруулахын тулд юуны түрүүнд Бурханы үг сургааль ба залбирлаар ариун байдлыг бий болгох ёстой хэмээн зорилт тавин ажиллаж байна.

7хоног бүрийн Эзний өдрийн 1-р Их Хүндэтгэлийн цуглааны дараа эрэгтэйчүүдийн бүлгийн дүүргийн ахлагч нар, өглөө 8:30д хэсгийн ахлагч нар, орой 19:30д эсийн бүлгийн ахлагч нар хамтдаа Эзний үгийг судладаг. Тэд “Загалмайн утга учир”, “Хайрын бүлэг”, “Ариун Сүнсний 9 үр жимс”, “8-н ерөөл” гэсэн сургаалийг судлаж, орой бүрийн Даниел залбиралд гал халуун залбирч байгаа юм.

Үүний үр дүнд маш хурдацтайгаар сүнсээр өсөөд зогсохгүй, айл эргэлтээр дамжуулан шинээр ирсэн итгэгчид, болон бүлгийн гишүүдээ амжилттай сайн удирдаж, өөрсдөө ч бусад итгэгчдийн сүнсний өсөлтөнд ч сайнаар нөлөөлж байгаа билээ. Тэд ямар ч төрлийн цуглааныг хөтлөх, номлох, сүнслэг хайраар бусдыг халамжлах чадвартай болохын төлөө зүтгэж байна. Ингэснээр мөн эрэгтэйчүүдийн эсийн бүлгийн цуглаан сэргэж, итгэгчид нь Ариун Сүнсээр дүүрэн болсон.

28-р эрэгтэйчүүдийн бүлгийн ахлагч Сун И хи сүмд үйлчлэгч (56 настай) “Би элэгний В гепатитээс болж бие болоод сэтгэл санааны хувьд маш хүнд байдалд байх үедээ сайн мэдээг хүлээн авч, Манмин сүмд И Жей руг пасторын залбирлаар бүрэн эдгэрсэн юм. Түүнээс хойш намайг эдгээж өгсөн Бурханы ивээлд талархан, сайн мэдээ тараах үйлсэд өөрийгөө зориулахаар шийдэж, бусдыг гал халуунаар хайрласан сэтгэлээр бүлгийн ахлагчийн үүргээ биелүүлж байна.”

22-р бүлгийн ахлагч И Жей гюн ахлагч (48настай) “Би худалдаа эрхэлдэг бөгөөд Бурханы сургаалийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх гэж хичээхэд хормын дотор хохирол амсаж болохуйц эрсдэл дунд

байдаг ч эцэст нь Бурханаар ивээгдэх гайхамшигийг мэдэрсэн юм.Түүнчлэн аравны нэгийн өргөл ч өсөх ерөөлийг авч байна” гэж гэрчилсэн юм.

17-р бүлгийн ахлагч Им Наг хун ахлагч (47 настай) “Би бүлгийн ахлагчаар үйлчлэх хэдхэн жилийн хугацаанд хүмүүсийн төлөө хайрын талаар маш олон зүйлийг сурч, мэдэж үүний зэрэгцээ би өөрөө ч сүнсээр өсөж, миний сэтгэл өмнөхөөсөө арай уужим сэтгэлээр бусдыг илүү хайрлахыг хичээдэг болсон” гэж ярьлаа.

Түүнчлэн Эрэгтэйчүүдийн багийн дүүргийн ахлагчдын зөвлөлийн тэргүүн Пак Хун ги ахлагч (55 настай) нь хүнд өвчнөөсөө И Жей руг пасторын залбирлаар эдгэрч, эрүүл саруул амьдралаар амьдарч байгаа билээ. Тэр одоо Лий энд Ко компанийн хуулийн зөвлөхөөр ажиллаж байгаа билээ. Тэрээр өөрийн үйлчлэлийнхээ талаар бидэнд танилцуулахдаа “Манай дүүргийн ахлагчдын зөвлөлд нийт 44 эрэгтэй удирдагчтай. Нэг дүүргийн ахлагч нь 2-3н бүлгийн удирдагч, болон 7-9н эсийн бүлгийн ахлагч нартай хамтран ажилладаг. Бид эрэгтэй итгэгчдийг гэм нүглээр дүүрсэн дэлхийг ялан дийлж, дэлхийн гэрэл, давс болж амьдрахад нь туслаж, Сүнс болон махан биеийн аль

аль талын ивээл авахад эсийн бүлгээр, багийн уулзалтаар эсвэл хувьчилсан зөвлөгөө өгч тусладаг” гэлээ.

Эрэгтэйчүүдийн бүлгийн удирдагчдын зөвлөлийн тэргүүн Шин Хэн чол ахлагч (55 настай) “Манай бүлгийн удирдагчид нь Бурхан болон Эзэнээс, тэргүүн пастораасаа авсан хайрыг бусдад сайн дамжуулан бүлгийнхээ сэргэлтээр баярлуулъя гэсэн сэтгэлээр хичээн зүтгэж байна” гэж ярьсан билээ.

Эсийн бүлгүүдийн ерөнхий удирдагч (Сүмийн орчуулгийн товчооны удирдагч) И Сан вон ахлагч (47 настай) өөрийн ажлын талаар өгүүлэхдээ “Эсийн бүлгийн удирдагч бид бүхэн 8 сарын 25наас 9 сарын 27 хооронд айл эргэлтийн тусгай хөтөлбөрийг боловсруулж, энэ хугацаанд болон цаашид ч Эзний ивээлээр олон хүмүүстэй хамт Шинэ Иерусалимд заавал орохын төлөө зүтгэх болно” гэж байлаа.

Эрэгтэй удирдагч нар гэр бүл, сүм, ажил гээд бүх салбарт итгэмжтэй байхыг хичээн зүтгэж байгаа ба энэ нь үхэж буй олон сүнснүүдийг авралын зам руу замчилж, аврал авсан хүмүүсийг итгэлээр өсөхөд нь туслаж, Бурханы хаанчлалыг улам тэлэхэд, баг бүлгүүдэд маш их тус дэм болно хэмээн найдаж байгаа билээ.



# Нигүүлсэл ба Сайн үр жимсээр дүүрэн мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



И Жей руг пастор

‘Нигүүлсэл’ гэдэг үгийг тайлбар толь бичиг дээр үзвэл “уучлах, бусдыг өрөвдөх” гэсэн байдаг. Гэтэл сүнслэг утгаараа нигүүлсэл гэдэг бол зөвхөн бусдыг өрөвдөх төдийгүй “нэг хүний сүнсийг ч бүх тэнгэр газраас ч эрхэмд тооцох сэтгэл”-г хэлдэг. Энэ нь ямар ч найдваргүй мэт харагдах хүн байлаа ч шантаралгүй эцсийн хүртэл аврал уруу хөтлөх зүрх сэтгэлийг хэлж байгаа юм.

Энэ мэтчилэн Эзэн дотор нигүүлсэх сэтгэлээр хандсанаар Ариун Сүнсний хүч нөлөөн дор бий болох бүх үр жимс нь “Сайн үр жимс” болдог учир нигүүлсэл ба сайн үр жимс нь хоорондоо маш нягт холбоотой болохыг харуулж байна. Тэгвэл одоо нигүүлсэл, сайн үр жимсээр дүүрэн мэргэн ухааны тухай үзэцгээе.

## 1. Сайн үр жимс нь нигүүлсэлээс гардаг

Бурхан бол Өөрөө тэр чигээрээ хайр, нигүүлсэл юм. Хэрэв Бурхан гэмтэнүүдийг уучилдаггүй, мөн хуулийн дагуу тэдэнтэй хатуу харьцдаг бол энэ дэлхийд хэн амьд тэсэж үлдэх билээ? Харин Бурхан хайр нигүүлсэлээ үзүүлж байгаа учраас бид гэмших боломжийг аваад зогсохгүй аврагдах арга замыг хүртэл олгосон юм.

Бидний Бурхан Аавын зүрх сэтгэл шиг Эзэний сэтгэл бас нигүүлсэлээр дүүрэн билээ. Магай 12:20д Есүсийн нигүүлслийн тухай “Тэр шударга ёсыг ялалтад хүргэтэл бяцлагдсан хулсыг хугалахгүй, сүүмэлзэх зулыг ч бөхөөхгүй” гэсэн байдаг. Есүс аврал авах ямар ч итгэл найдваргүй яг л бяцлагдсан хулс, сүүмэлзэх зул мэт болсон хүмүүсийг ч хүртэл тэсэн тэвчсэн билээ. Тэр уучлалын талаар номлож, биеэ үнэлэгч болон татвар хураагч мэт ад үзэгдэн доромжлогдсон хүмүүст хүртэл сайн мэдээ тарааж байсан. Яагаад гэвэл Тэр зөвт хүмүүсийн төлөө биш гэмт хүмүүсийг

гэмшүүлэхийн төлөө ирсэн юм (Лук 5:32).

Есүс Искаротын Иудаг хүртэл “авралыг хүлээж авах сэтгэл чамд алга” гэж айлдаагүй билээ. Харин түүнийг эцсийн мөч хүртэл нь авралын боломжыг өгсөн юм. Тэгээд эцэст нь Өөрөө хүн төрөлхөнд авралын замыг нээж өгөхийн тулд загалмайд цовдлогдон нас барсан юм. Үй олон хүн Түүний ариун цусны үнэ цэнээр аврагдаж, нигүүлсэлээр дамжин гарсан “сайн үр жимс” юм.

## 2. Амийг өгдөг нигүүлсэлийн мэргэн ухаан

### 1) Бусдын үүднээс ойлгож, уучилдаг нигүүлсэл

Ефес 4:32д “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” гэсэн байдаг. Бурхан Аав, Эзэн маань биднийг хайрлаж, уучилсаны адилаар та нар ч бие биеэ уучил хэмээн айлдсан байдаг. Бусдыг уучилж, өршөөнө гэдэг нь өрөөл бусдын зүгээс тэднийг харж, ойлгох шаардлагагай болдог. Бид магадгүй өөрийн үзэл бодол, өөрийнхөө байр суурьнаас хараад байдаг болохоор бусдыг тэр бүр ойлгож чаддаггүй байх. Тэгвэл бид өөрсдийгөө бусдын оронд тавиад үзвэл ямар ч нөхцөл байдал байсан ойлгож, уучилж чадна.

Жишээ нь итгэгч биш эцэг эх эсвэл таны нөхөр (эхнэр) тань таныг хавчих үед та ойлгож өгөхгүй бол гомдоллож, дургүйцэж магадгүй. Хэрэв та тэднийг ойлгохгүй бол хайрлаж чадахгүй, мөн айдас, таагүй байдлаас нь болж тэднээс зүгээр л зайлсхийж болох юм. Яг амьдрал дээр итгэгч эхнэр итгэгч биш нөхрөө ойлгодоггүй тохиолдол олон бий. Эхнэр нь зөвхөн өөрийн зүгээс, өөрийнхөө байр сууринаас сүмийн тухай, итгэлийн тухай яривал хэрүүл маргаан болоод хувирчихдаг тохиолдол их байдаг. Тиймээс та зөвхөн нөхрөө (эхнэрээ) буруутгахын оронд харин та өөрийгөө түүний оронд тавьж, сэтгэлийг ойлгож, түүний зүгээс, үзэл бодлынх талаар бодох хэрэгтэй. Тэр үед л та мэргэн ухааныг хүлээн авах болно.

### 2) Зэмлэх, шийтгэх мэргэн ухаан

Уучлал, зэмлэл хоёр нь эсрэг тэсрэг юм шиг сонсогдож байгаа ч яг үнэндээ бол тийм биш юм. Яагаад гэвэл зэмлэх мэргэн ухаан бол ямар нэгэн гомдол, шүүмжлэл, үзэн ядалт байхгүй зөвхөн хайраар ханддаг. Энэ нь зөвхөн Бурханы нигүүлслийн дагуу зэмлэл, шийтгэл байдаг. Тэр хайрладаг хүмүүсээ зэмлэдэг. Хэрэв бидний гэм нүгэл хэрээс хэтэрвэл гэмийн хана босож, Бурхан биднээс эргэсэн тохиолдолд ямар зэмлэл, шийтгэл ирдэггүй. Тиймээс Еврей 12:6 “Учир нь Эзэн хайрладаг хүнээ

сахилгажуулдаг юм. Тэр хүлээн авдаг хүү болгоноо ташуурддаг” гэжээ.

Зарим хүн алдаа дутагдал, буруугаа нуун далдахыг хичээж ямар нэгэн шалтаг, шалтгаан тоочиж шийтгэл, зэмлэлээс зугтдаг. Эсвэл буруу нь илрэх үед сэтгэлээр унаж, урам зориггүй болдог. Харин бид чин сэтгэлээсээ гэмшиж, буруу замаасаа бүрэн эргэж чадвал Бурхан биднийг заавал уучилж хүнд хэцүү байсан асуудлуудыг шийдэж, шинэчилж өгнө. Тэр бидний урьд өмнөх гэм нүглийн дурсах ч үгүй.

Заримдаа та итгэлийн ахан дүүсийнхээ гэм бурууг мэдээд тэднийг зэмлэх, зөвлөгөө өгөх тохиолдол гарч магадгүй. Тэгвэл та эхлээд өөрийнхөө сэтгэл зүрхийг маш анхааралтай, няхуур шалгаж үзэх хэрэгтэй. Та мэдээж зөвлөгөө өгөхдөө хайрын сэтгэлээр өгч байгаа ч бусдын гэмийг онцлон бодож ямар нэг талаар өөрийн зөв, эрх ашгийг харж, атгаг санаа өвөрлөсөн байх вий. Мөн та тэдэнд заахыг хичээж, өөрийн хүссэн зүйлээ хийлгэхийн тулд өөрийгөө тэднээс өндөрт тавьж хянаж, захирах гэсэн хандлага ч байж магадгүй юм. Тиймээс Бурханы үгийн дагуу хайраар л үйлдэхгүй бол Ариун Сүнсний ажлыг ойлгож, ухаарч чадахгүй юм.

Иймэрхүү байдлаар зөвлөгөө өгвөл бусдыг ойлгож чадахгүй харин зүрх сэтгэлийг нь шархлуулаад зогсохгүй дургүйг нь хүргэх болно. Өөрийн алдаа дутагдал гэм буруугаа бүр сайн олж мэдэж ухаарыг хичээж байгаа хүн таны зөвлөгөө, шүүмжийг сонсоод шархалж, урам нь хугарч, гутраад бүр цаашаа явчихаж болно.

Тиймээс хүмүүст зөвлөгөө өгөхдөө эсвэл зэмлэхдээ бид сүнслэг хайр, нигүүлсэл дотор тэр хүний оронд өөрийгөө тавьж, зөв ойлгож байж өгөх хэрэгтэй. Мөн түүний төлөө залбирч, хайраар зөвлөж, өөрийн амьдралаа ч хүртэл зориулж чаддаг байх хэрэгтэй. Ийм сэтгэлээр зөвлөж, зэмлэвэл бусдад амь, амьдралыг өгч чадна.

### 3) Бусдад тусламжийг өгдөг нигүүлсэл

Хэрэв бидэнд сүнслэг хайр, нигүүлсэл байвал тусламж дэмжлэг хэрэгтэй хүмүүсийг харахдаа өрөвдөөд зогсохгүй бодитоор тусалж өгдөг. Жинхэнэ нигүүлсэл гэдэг нь 1 Иохан 3:18д бичигдсэнчлэн үг хэлээр бус ажил үйлс болгон бодитоор туслахыг л хэлж байгаа юм.

Бурханы үр хүүхдүүд нь сайн мэдээ сонсоогүй, үнэнийг мэдээгүй байгаа хүмүүсийг ч хайрлах хэрэгтэй. Яагаад гэвэл бид хавчигдах юм уу бүр амийн аюулд тулгарсан ч сайн мэдээг тараана гэдэг маань нигүүлсэх сэтгэлийн үүднээс үйлдэж байгаа учраас юм. Мөн ганцаардаж, сэтгэлээр унасан, гадуурхагдсан, өвчтэй, сул дорой хүмүүсийг хүртэл хайрлах ёстой

юм.

Яг ингэж хайр нигүүлсэлээ харуулж чадвал Бурхан бидэнд Өөрийн нигүүлсэлээ ч харамгүй харуулах болно. Бурхан бидэнд тарьсаных нь хэрээр дүүргэл бялхтал илүү их ивээл ерөөлийг цутган өгөх болно (Лук 6:38). Тийм учраас л үүнийг бусдад туслах мэргэн ухаан гээд байгаа юм.

Гэхдээ бусдад туслахдаа хэнд, ямар үед туслах ёстойгоо сайн ялгаж салгадаг байх хэрэгтэй. Бид эхлээд итгэгч гэр бүлд туслах хэрэгтэй. Хууль дүрэм санаатай зөрчиж санхүүгийн хямрал, өр ширэнд орсон хүмүүс, мөрийтэй тоглоом тоглодог, архи уудаг, ажил хийх дургүй хүмүүст туслах нь зохистой зүйл биш. Харин ч эсрэгээрээ хүнд хэцүү байдлыг амсаж болзошгүй ба тусламж авсан хүндээ ч хохирол учирч магадгүй юм.

## 3. Сайн үр жимсээр дүүрэн нигүүлсэлийн мэргэн ухаан

Бидэнд хайр, нигүүлсэл хэдий их байна төдий чинээ сайн үр жимсээр дүүрэн байх болно. Нигүүлсэлээр хийсэн бүхий л зүйл Ариун Сүнсний хүч чадлаар үзэсгэлэнтэй сайхан үр жимсийг гарцаагүй гаргадаг. Юуны өмнө олон хүнийг авралын замд замчилсанаар үр жимсийг олж авч, зүрх сэтгэлдээ сайн үр жимсийг ургуулах болно. Бидний эсрэг хорон мууг үйлддэг хүмүүст хүртэл сайнаар хандах, залбирлын анхилуун үнэрийг гаргах, сайхан сэтгэл гэх мэт сайн үйлс нь бүгд сайн үр жимсийг гаргаж Тэнгэрийн оронд ч, энэ дэлхийд ч нэр төр, хүндлэлийг авах болно.

Бидний аврагч Эзэн Есүс үгээр хэлэхийн аргагүй тийм агуу нигүүлсэлээрээ тоо томшгүй олон үр жимсийг хурааж авсан билээ. Тэр үхэхээс өөр аргагүй байсан хүмүүсийн төлөө хайр, нигүүлсэлээ харуулж Өөрийн биеэрээ бидний өмнөөс загалмайн зовлонг туулж, ингэснээр үй олон хүн аврагдах үр жимсийг гаргасан юм.

Хайрт итгэлийн ахан дүүс минь, танд хор хохирол учруулдаг, эвгүй зан гаргадаг, таныг гомдоодог хүмүүст та яаж ханддаг вэ? ‘Тэр хүнийг хармааргүй байна...’ эсвэл ‘тэр бушуухан эндээс нүүгээсэй’ гэж боддоггүй биз дээ? Бурхан биднийг хайр нигүүлсэлээр дүүрч, хүн бүрийг хайрлан халамжилж, сайн үр жимсийг гаргаасай гэж хүсдэг.

Та бүхнийг хөршөө үнэн дотор үйлсээрээ хайрлаж, шархалсан зүрхийг нь тайвшруулж, хэрэгцээтэй зүйлсээр нь туслаж дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Эдгээрийг үйлдэж Бурханыг баярлуулан нигүүлсэлээр үр жимс гарган, сайн сайхнаар бялхсан дүүрэн байхыг Их Эзэний нэрээр хүсэн ерөөе.

## Монгол Манмин Сүм

### Мэргэлийн цаг

Мэргөл	Цаг
Их мэргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мэргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мэргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мэргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мэргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мэргөл	Хагас сайн өдөр 16: 30

### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.gcntv.org

# Итгэлийн амьдралын гол зорилгодоо хүрэх өөрийгөө шалгах гурван чухал асуулт

Таны Христэд итгэх, итгэлийн амьдралын зорилго юу вэ? Хэрэв та Эзэнд үнэхээр хайртай бол Түүний үзэсгэлэнтэй сайхан сэтгэлийг дуурайж, үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимд орох явдал нь бидний итгэлийн амьдралын гол зорилго юм. Одоо та доорх гурван асуултанд хариулж өөрийгөө зорилгодоо хүрэхийн тулд хир зэрэг амжилттай явж байгаагаа шалгана уу.

## 1. Та зорилгодоо хүрэхийн тулд хувирашгүй бат зогсож чаддаг уу?

Бид бүхэн тодорхой нэг зорилго тавиад түүнийхээ төлөө явж байхдаа анх товлосон зүйлийнхээ дагуу зөв явж байгаагаа мэдэх гэж шалгах нь зүйн хэрэг билээ. Та марафон гүйлтэнд гүйж байна гэж бодъё. Эхэндээ та барианы шугам чиглэн гараанаас хөдөлсөн ч замын дунд ирээд эргэлзэж эхлэвэл, мөн өөр зүйлд анхаарвал таны хувьд уралдаанд ялж, түрүүлэх зорилго бүтэхгүй болж болзошгүй.

Үүний нэгэн адил сүнслэг тэмцээний үед буруу зам руу будилж, анхаарлаа өөр тийш хандуулвал бид зорилгодоо тийм ч амархан хурдан хүрч чадахгүй юм. Зөвхөн сүнслэг зүйлийг л харж, сонсч, бодох гэх мэтээр өөртөө хатуу шийдэхэд зурагт үзэх, өөрт

таалагдсан зүйлийг хийж, дэлхийн зүйлд дурлаж байхын оронд Бурханы үгээс суралцаж, сургаал сонсож, сонссон сургаалиа дахин дахин сонсож, бясалгах, сүмдээ ирэн залбирах тал дээр хичээх ёстой.

Та сүнслэг зорилго тавиад түүнийг биелүүлэхээр шийдсэн бол дахин дэлхийн найзууд, зугаа цэнгэл рүү таны анхаарал татагдаж байна уу гэж өөрийгөө одоо нэг шалгаад үзээрэй. Адамыг унагасан дайсан Сатан диавол хүмүүсийг дэлхийн зүйлээр урхидан уруу татаж унагаахыг хайр найргүй улангасан хичээн зүтгэсээр байгаа тул өөрийгөө үргэлж шалгаж, хянаж байх шаардлагатай.

“Та нар оюун ухаанаа газар дахь зүйлс дээр биш, харин дээгүүрх зүйлс дээр төвлөрүүл” (Колоссай 3:2) гэж айлдсаны эсрэг сатан Бурханы хүмүүсийн оюун ухааныг дэлхийн зүйлс рүү хандуулж удирддаг.

Тиймээс та өөрийгөө мөнгө, нэр хүнд, эрх мэдэл, дэлхийн зугаа цэнгэл, аз жаргал, эсрэг хүйстэний харьцаанд илүү их анхаарал тавьж байна уу, дэлхийн найз нөхөдтэй байх нь сүмийн ахан дүүстэй байхаас илүү хөгжилтэй, сонирхолтой байна уу, Бурханаас илүү дэлхийн зүйлд найдаж байна уу гэдгээ сайтар шалгаж хянах хэрэгтэй. Энэ талаар дахин нэг анхааралтай бодоод өөрийгөө шалгаж үзээрэй.

## 2. Та тасралтгүй дуудан залбирч байна уу?

Хэрэв та гал халуун залбирдаггүй бол зорилгодоо хүрэх гэж хичнээн их зүтгээд ч нэмэргүй, танд хүч өгөгдөхгүй. Та үнэний мэдлэгээр өөрийгөө маш хүчтэй зэвсэглэсэн ч чанга дуугаар залбирдаггүй бол, гал халуун залбирахгүйгээр Ариун Сүнсээр дүүрдэггүй учраас үр жимсгүй байдаг.

Зөвхөн залбирал үгийг бидний зүрх сэтгэлд суулгаж, бас сонсож, үр жимсийг 30, 60, 100 дахин ургуулж чаддаг. Библийн маш олон газар залбирлын чухлыг онцлон тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: 1 Тесалоник 5:17д “Тасралтгүй

залбир”, 1 Петр 4:7д “Бүх юмсын төгсгөл ойр ирчихээд байна. Тиймээс зөв шүүн тунгааж, залбиралдаа эрүүл байгтун” гэсэн байдаг. Маш олон христэд итгэгчид зөвхөн Ням гаригийн цуглаан дээр л залбирдаг.

Итгэлээ хамгаалахын тулд сорилтонд орохгүй байж, Христэд итгэдэг хүн бүр Эзэний заасаны дагуу заншсан ёсоороо залбирах хэрэгтэй. Залбиралгүй бол итгэлээ хадгалж үлдэхэд маш хэцүү бөгөөд гэм нүгэл ноёрхсон энэ дэлхийд аврал авахад ч амар биш юм. Тиймээс залбирал бол зүгээр нэг сонголт биш Христчин

хүмүүсийн зайлшгүй хийх ёстой зүйл бөгөөд залбирахгүйгээр дэлхийг ялан дийлэх боломжгүй юм.

Залбирал бол сүнсний амьсгал, Бурхантай харьцаж, холбоо тогтоож, сүнслэг ертөнцийг мэдэх, сүнс рүү орох цорын ганц зам мөн. Та бүхний зарим нь залбирахгүй байсан ч сүмд хичээнгүйлэн ажилладаг байж болох юм. Тэглээ ч таны сүнс өсөж, чадахгүй тул та хэр зэрэг тасралтгүй болоод чин сэтгэлээсээ чанга дуугаар дуудан залбирч байгаа эсэхээ дахин нэг шалгаж үзээрэй.

## 3. Та сайн үйлсийг хэр зэрэг үйлддэг вэ?

Гал халуун залбирч зорилгоо биелүүлэхийн төлөө хичээн зүтгэж сайн ажилласан ч та амьдралдаа хир зэрэг хайр, сайхан сэтгэлийг хэрэгжүүлэн амьдарч байгаа талаар өөрийгөө шалгаж үзээрэй. Олон итгэгчид гэм нүгэлээ хаяж, хорон муу, атгаг санаагүй болж ариусалыг олж авахын төлөө хичээн зүтгэдэг боловч ‘сайныг’ үйлдэх тал дээр дутмаг байдаг. Маш идэвхитэй, урам зоригтойгоор сайныг үйлдсэнээр сүнслэг итгэлтэй болж чадна.

Зүгээр идэвхигүй гэм нүгэл үйлдэхгүй байхыг хичээх, сайныг үйлдэх гэж хичээх нь хоорондоо маш их ялгаатай. Жишээ нь хоёр хүүхэдтэй ээж байлаа гэж бодъё. Нэг хүүхэд нь аль болох ээждээ зэмлүүлэхгүй байхыг хичээдэг бол нөгөө хүүхэд нь ээжийгээ аль болох баярлуулах гэж хичээдэг бол хэн нь илүү ихээр ээжийнхээ хайрыг хүлээн авах бол?

Үүнтэй адил бид ч бас Сургаалт үгс 8:17д “Намайг хайрлагсдыг би хайрлана. Намайг

хичээнгүйлэн хайдаг нь намайг олно” гэж бичигдсэнчлэн Бурханыг хайрлаж, идэвхитэй, хичээл зүтгэлтэйгээр Түүнийг хайх хэрэгтэй.

Сайныг үйлдэхдээ ч бид чин сэтгэлээсээ, илүү сайхан сэтгэлээр хийх ёстой. Мэдээж сайхан сэтгэлээр өгч, үйлчилдэг ч хамгийн чухал нь бидний зүрх сэтгэлд хайрлах сэтгэл нэгдүгээрт тавигдах ёстой.

Тиймээс сайны үйлс чухал ч гэсэн хамгийн чухал нь бусдын эрх ашгийг хайх, бусдад үйлчлэх, бусдын төлөө зориулах золиослох сэтгэл надад хэр зэрэг байгаа талаар шалгаж үзэх хэрэгтэй юм. Таны эргэн тойронд байгаа хүмүүс таны нөлөөгөөр амар тайван, аз жаргалтай байж чадвал түүнийг л жинхэнэ сайхан сэтгэл гэж хэлж болох юм.

Сайхан сэтгэл бол сүнслэг анхилуун үнэр юм. Хичнээн жаахан зүйл байсан ч сайхан сэтгэлээр хийсэн л бол сайхан мэдрэмжээр дүүрэн байдаг. Сайхан сэтгэл нь сайтар бодож төлөвлөх, эсвэл

зөвхөн суралцах биш харин аяандаа чин сэтгэлийн угаас гарч, тэр нь үйлдэл болохыг хэлнэ. Хэдий жаахан зүйл үйлдсэн ч цааш үргэлжлүүлэн амьдралдаа хэрэгжүүлсээр л байвал илүү их өсдөг онцгой шинж чанартай тул сайны зүрх сэтгэл нь өссөөр бүр илүү гүнзгий сайны давхаргад ч хүрч болдог.

Энд та өөрийн сурч мэдсэнийхээ дагуу сайныг үйлдэж, “Би ийм сайхан зүйл хийлээ” гэж өөртөө сэтгэл хангалуун байх бус зүрх сэтгэлийн угаас гарах тэр сайны мэдрэмжээрээ үйлдэх тийм жинхэнэ сайн зүрх сэтгэлийг бий болгохын төлөө хичээн зүтгэх ёстой.

Тиймээс би хэр зэрэг сайн үйлдэж байна вэ? Ингэхдээ албадлагаар юм уу эсвэл өөрийн үнэний мэдлэг дээрээ тулгуурлан хийж байна уу? Эсвэл чин сэтгэлийн гүнээс сайныг үйлдэх нь аз жаргалтай болгодог гэдгийг мэдээд үйлдэж байна уу? гэдгээ шалгаад нэг үзээрэй.



## “Агуу хүчтэй залбирлаар хараа минь сайжирсан учир үнэхээр аз жаргалтай байна”



Жү Хёон гуон пастор (61 настай)

Эзэнийг хүлээн авсанаас хойш сүүлийн 35 жилийн турш эмчид үзүүлэх, эм уух огт шаардлаггүй амьдарч ирсэн юм. Харин нэг асуудал бол 1996 оноос хойш нүдний хараа муудаж эхэлсэн. 2000 оноос эхлэн 0.3 (зүүн нүд) 0.5 (баруун нүд) харааны шил зүүж эхлэсэн юм.

Нэг талын нүд нь бараг хараагүй шахуу манай ээж И Жон сүн халамжлагч энэ удаагийн 2014 оны Манмины Зуны цуглаанд бэлдэн нүдээ эдгээхийн төлөө өргөл бэлдэн И Жей руг пастораас залбирал авсан юм. Тухайн үед миний нүдний төлөө ч бас сэтгэлдээ агуулан залбирал авсан байжээ.

Тэгээд 8 сарын 3нд зуны цуглааны өмнөх шөнө би нэгэн зүүд зүүдэлсэн бөгөөд тэр зүүдэнд нэг хагиг хагарч, хагигны цул хэсэг нь гарч ирж байна гэж зүүдэлсэн юм. И Жей руг Тэргүүн пастораас “Энэ удаагийн зуны цуглаан нь урьд урьдны зуны цуглаануудаас илүүтэйгээр агуу эрх мэдэлт хүч чадал илрэн гарах болно” гэж сургааль дээр хэлж байсныг санан энэ удаад үнэхээр миний хувьд сүнс болон махан биеийн ивээл ерөөл авна гэсэн найдлага тавьж зуны цуглаанд оролцсон.

Зуны цуглааны эхний оройн цуглааны номлолын үеэр ивээлийн бороо зөөлөн орж байлаа. Тэр үед нүдний шил бороонд нурууд харж болохгүй байсан болохоор шилээ аваад сургаалыг маш анхааралтай сонсож байлаа. Тэгж байтал гэнэт л бүрэлзэж харагдаад байсан юмс маш тод тунгалаг харагдаж эхэлсэн. “Хүүе! Юу билээ? Миний хараа сайжирчихсан байна!” гээд түрийвчнээсээ нэрийн хуудас гаргаж ирээд уншиж үзлээ. Би жижиг үсгийг хүртэл уншиж чадаж байлаа!

Номлолын дараах эдгэрлийн цуглаан дээр гараа нүдэн дээрээ дараад И Жей руг пасторын залбирал авахад нүдний хараа улам сайн болсон учраас маргааш өдрийн буухиа тэмцээнд нүдний шилгүй оролцсон. Тэрч байтугай харанхуй бороо орж байхад би гэрлүүгээ машинаа шилгүй бариад харьсан юм. Халлелуяа!

## “Манмин төв сүмд ирсэнээр миний бүх өвчин эдгэрч, Бурханы агуу хайрыг мэдэрч байна!”

Биэн Хүөн Лиле (43 настай, Франц)



Олон хүн надад өөрсдийн шүтдэг шашиныхаа талаар ярьж санал болгодог байсан ч алинд нь ч итгэдэггүй, шашингүй үзэлтэн байлаа. Харин найз Жанет маань Манмин төв сүмийн талаар ярихад нэгэн тав дахь өдрийн оройн цуглаанд интернетээр оролцсон.

И Жей руг пасторын сургаалыг үнэхээр сэтгэл хөдлөж, Ариун Сүнсээр дүүрсэн билээ. Би мөн магтаал дуугаар ч дамжуулан гайхамшигтай аз жаргалыг амсаж билээ. Үүнээс хойш Эзэний өдрийн мөргөл, Баасан гаригийн шөнийн мөргөл, орой бүрийн Даниел залбирлаас жинхэнэ аз жаргал, баяр баясалыг мэдэрдэг болсон.

Ингээд эцэст нь Солонгост 2014 оны 6 сарын 26нд болсон удирдагчдын Семинарт оролцсон. Францаас хэд хэдэн итгэгчид ирж Баасан гаригийн шөнийн мөргөлд И Жей руг пасторыг ойроос харах боломж олдсон юм. Би түүний гэрэл цацарах мэт инээмсэглэсэн царайг хараад түүнтэй гар барих мөчид миний зүрх сэтгэлд байсан хүнд шарх эдгэрч байхыг өөрөө мэдэрч, сая л өөрийн жинхэнэ биеэ олох шиг болсон. Тэгээд хэмжээлшгүй их аз жаргалд умбаж, баярын нулимс

асгарч байсан юм.

Маргааш өглөө нь, Жанеттай хамт өглөөний цайгаа ууж байтал зүүн талын чихэн дотор загатнах шиг болохоор нь ухтал том том хатсан шархны тав гарч байсан. Гэхдээ энэ маш зөөлөн, гөлгөр тав байсан.

Яг үнэндээ би 5 жилийн өмнөөс эхлэн зүүн чихний үрэвсэлтэй болчихсон юм. Загатнах бүрт нь ухдаг байсан болохоор цус гарч, идээ бээр гоожно. Зүүн чихний хэнгэрэгний халс хөндийрч хавдаад маш их өвддөг байв. Өвчин улам даамжирч арьсанд нөлөөлөөд бас арьсны маажууртай болсон. Баруун чих маань хүртэл дунд чихний үрэвсэлтэй болж хавдаж үргэлж хөвөнтэй жин тавьдаг байлаа. Жаахан гайгүй болохоор нь тос дусаадаг ч мөн л удалгүй буцаад өвдчихдөг байв.

Гэвч Манмин төв сүмийг мэдсэнээс хойш би тос ч хэрэглээгүй. Харин оронд нь Бурханы хүч шингэсэн Мүан амтат усыг цацахад өвчин аяндаа багасдаг байв. Харин И Жей руг пастортай гар барих яг тэр үед баруун, зүүн чихний үрэвсэл, идээ, загатнаад байдаг маажуурын өвчин бүгд байхгүй болсон. Халлелуяа!

Ивээл зөвхөн үүгээр дуусаагүй. Би

осолд ороод зүүн шагайгаа булгалаад 5 сар ажил хийж чадаагүй юм. Солонгос явах онгоцонд суухад, болон алхахад маш их хөндүүрлэж өвддөг байлаа. Харин И Жей руг пастортай гар барьсаны маргааш нь ердөө л ганцхан өдрийн дараа шүү дээ, өдөржингөө өндөр өсгийтэй гутал өмссөн ч ямар ч асуудалгүй зүв зүгээр алхдаг болсон юм.

2014 оны 8 сард Зуны цуглаанаар Бурханы гайхамшигийг дахиад л мэдэрсэн. И Жей руг пасторын залбирлыг цээжиндээ гараа тавиад авч байхад хөлийн судас бүдүүрсэн байсан бөгөөд хөл холгосноос болж өвдөж, загатнаж, нэг л таагүй байлаа.

5 жилийн өмнө бага хүүхдээ гаргасаны дараа хөлний судаснууд бүрүүрч томроод юбка ч өмсөхөөс ичдэг байлаа. Өдөржингөө босоо ажил хийдэг байсан болохоор бүр ч их өвдөж, өвчин намдаах эм ууж, жин тавих зэргээр өвчнийг нь жаахан намдаадаг байлаа. Өдөрт 4-с илүү цаг зогсвол цус нь хуралдаад судас нь бүр их бүдүүрдэг учраас хөлөө амрааж унтах юм уу, заавал амрах шаардлагатай болсон.

Эмч нар хагалгаа хийлгэх шаардлагатай гэж надад зөвлөдөг байв.

2014 оны зуны цуглаанаар И Жей руг пасторын залбирлаар би бүр цоо эрүүл болсон. Хүйтэн хөндий байсан зүрх сэтгэл маань гал халуун болохыг мөн, жинхэнэ аз жаргалыг мэдрэх үед өөрийн эрхгүй баярын нулимс урсан, амар тайван зүрх сэтгэлд минь ирсэн юм. Тэгээд би өвчтэй газруудаа шалган үзэж, хөлөө маш сайн ажиглаж үзлээ. Зүүн хөлөнд байсан бүх шинж тэмдгүүд байхгүй болж, баруун хөлөнд үл мэдэгдэм жаахан шинж тэмдэг үлдсэн байсан. Тун ч удалгүй тэр жаахан хөндүүрч үл мөргүй алга болсон юм.

Бүх талархал, алдар, магтаалыг намайг эдгээж өгсөн Бурханд өргөж байна. Мөн И Жей руг пастортаа намайг үнэнээр босгон байгуулж, миний төлөө залбирч өгсөнд баярлалаа.

### УБ Ариун баярт мэдээ чуулган

#### Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

#### залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

#### Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

## Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
http://www.manmin.org/english  
www.manminnews.com  
e-mail: manminministry@manmin.org  
Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин